



"Үйлдвэрийн хаягдал усыг урьдчилан цэвэрлэх төлөвлөгөө"-г хэлэлцлээ



Монголын Мянганы сорилтын сан (Монголын МСС)-аас Компакт гэрээний хүрээнд боловсруулж буй "Үйлдвэрийн хаягдал усыг урьдчилан цэвэрлэх төлөвлөгөө"-г хэлэлцэх хэрэгжүүлэгч талуудын төлөөллийг оролцуулсан цуврал хэлэлцүүлэг 2020 оны 11 дүгээр сарын 3, 6-ны өдөр Гадаад харилцааны яамны "Зөвшилцөл" танхимд боллоо. Хэлэлцүүлэгт төлөвлөгөөг хариуцаж болон хамтран хэрэгжүүлэх төр, засгийн байгууллагууд, үйлдвэрлэлийн холбоод, аж ахуйн нэгжийн төлөөлөл, эрдэмтэн судлаач нар оролцов. Цуврал хэлэлцүүлэг 2020 оны 11 дүгээр сарын 10 болон 13-ны өдөр үргэлжилнэ. [Эх сурвалж: Монголын МСС https://mca-mongolia.gov.mn/news/press-news/wra-ipp-discussion](https://mca-mongolia.gov.mn/news/press-news/wra-ipp-discussion)

"Усан орчин хамгаалал, менежмент" сэдэвт эрдэм шинжилгээний бага хурал боллоо



ХААИС-ийн Агроэкологийн сургуулийн Экологийн тэнхимээс санаачлан "Усан орчин хамгаалал, менежмент" сэдэвт эрдэм шинжилгээний бага хурлыг 2020 оны 11 дүгээр сарын 6-ны өдөр Цэнгэг усны нөөц, байгаль хамгаалах төвд зохион байгууллаа. Усан орчны чиглэлээр сургалт, судалгаа явуулдаг их, дээд сургууль, эрдэм шинжилгээний байгууллагын эрдэмтэн судлаачид, төрийн болон төрийн бус байгууллагын төлөөлөгчид оролцож, тус салбарын өнөөгийн байдал, тулгамдаж буй асуудал, цаашид усан орчныг хамгаалахад ямар нэгдсэн бодлого хэрэгжүүлэх шаардлагатай талаар ярилцлаа. Энэ үеэр Монгол Улсын хэмжээнд усны чиглэлийн 3691 мэргэжилтэн байгаа бөгөөд цаашид энэ тоог нэмэгдүүлэх, залгамж халааг бэлтгэх шаардлагатай байгааг онцлов. [Эх сурвалж: ХААИС /https://muls.edu.mn/view_news.php?value_id=ZW5jb2RldXNlcmIkMzAwMQ==/](https://muls.edu.mn/view_news.php?value_id=ZW5jb2RldXNlcmIkMzAwMQ==/)

Төв цэвэрлэх байгууламжийн лагийг үнэргүйжүүлэх төсөл амжилттай хэрэгжиж дууслаа



Засгийн газрын 2018 оны 73 дугаар тогтоол гарч, Барилга, хот байгуулалтын сайдын тушаалаар Ажлын хэсэг байгуулагдан Төв цэвэрлэх байгууламжид хуримтлагдсан лагийг цэвэрлэж, үнэргүйжүүлэх ажлыг зохион байгуулсан бөгөөд 2020 онд амжилттай хэрэгжүүлж дуусчээ. Энэ ажлын хүрээнд хоногт 2,500 шоо метр лаг усгүйжүүлэх байгууламж шинээр барьж, 2019 оны 9 дүгээр сард байнгын ашиглалтад оруулжээ. Мөн Төв цэвэрлэх байгууламжид хуримтлагдсан 800,000 шоо метр орчим лагийг байгаль орчинд ээлтэй технологиор үнэргүйжүүлэн хоргүйжүүлэх ажлыг үе шаттай хийж гүйцэтгэсэн хэмээн эх сурвалжид мэдээлжээ. [Эх сурвалж: БХБЯ /https://mcd.gov.mn/a/645?fbclid=IwAR0yaLc6kFJVH12_eVSLkeG5YR1R3if587uCF66ZaNEqHEUJVRKEpTld64/](https://mcd.gov.mn/a/645?fbclid=IwAR0yaLc6kFJVH12_eVSLkeG5YR1R3if587uCF66ZaNEqHEUJVRKEpTld64/)

Нийслэлийн есөн дүүргийн 2255 уст цэгээс шинжилгээ авч, ундны усны чанарыг судалж эхэллээ



Нийслэлийн 9 дүүргийн 2255 уст цэг /гүний худаг, ус түгээх байр, ус дамжуулах хоолой/-ээс химийн 25, микро биологийн тав, изотопын тав, микро элементийн 56 нийт 91 үзүүлэлтээр шинжилгээ хийж, үзүүлэлт тус бүрээр ундны усны чанарын судалгааг гарган мэдээллийн сан үүсгэжээ. Уг ажилд Шинжлэх ухааны академийн Хими, химийн технологийн хүрээлэн, Газарзүй-Геоэкологийн хүрээлэн хамтран оролцож байгаа аж. Уг судалгаа, мониторингийн ажлын үр дүн, цаашид авах арга хэмжээний талаар Нийслэлийн Байгаль орчны газар, Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөл хамтарсан уулзалт хийсэн байна. [Эх сурвалж: ikon.mn /https://ikon.mn/n/20yz/](https://ikon.mn/n/20yz/)

ТОВЧ МЭДЭЭЛЭЛ

- * Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг "Усны газар" Усны салбарын Төрийн бус байгууллагуудтай тэдний үйл ажиллагаанд тулгамдаж буй асуудал болон хамтын ажиллагааг сайжруулах талаар санал солилцох уулзалт зохион байгууллаа. [Эх сурвалж: Усны газар болон Гидрогеологичдын Холбооны албан ёсны фэйсбүүк хуудас](#)
- * Монголын МСС болон Усны зохицуулах зөвлөлөөс хамтран Орон сууц, нийтийн аж ахуй, тэр дундаа Ус хангамж, ариутгах татуургын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн дунд зохион байгуулсан "Ус хангамж, ариутгах татуургын зардал нөхөх асуудал, Хөрөнгийн менежмент" сэдэвт зургаан өдрийн сургалтад салбарын байгууллагуудын нийт 370 гаруй төлөөллийг хамруулав. [Эх сурвалж: Монголын МСС](#)

ДЭЛХИЙН УСНЫ САЛБАРТ



"Сингапурын Олон улсын усны долоо хоног" (Singapore International Water Week) арга хэмжээ энэ жил анх удаагаа цахимаар 2020.11.18-19-ны өдрүүдэд зохион байгуулагдах гэж байна. Энэхүү арга хэмжээгээр энэ удаад хот, суурин газрын усны менежментийг онцолж байгаа бөгөөд ус дахин ашиглалт, ус ашиглалтын байгууллагууд дахь цахим шилжилт, усны менежментийг уур амьсгалын өөрчлөлтөд нийцүүлэх зэрэг олон сонирхолтой сэдвээр вэбинарууд зохион байгуулагдахаас гадна усны асуудлуудыг шийдсэн технологи, шийдлүүдийн экспо бас болох юм байна. Тус арга хэмжээний албан ёсны цахим хуудас (<https://www.siww.com.sg/>)-аар дэлгэрэнгүй мэдээлэл авах болон бүртгүүлэх боломжтой. [Эх сурвалж: https://www.siww.com.sg/](https://www.siww.com.sg/)